



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/47

Улаанбаатар хот

Эрдэм шинжилгээний бага хурал
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны түүхт 384 жилийн ойг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын дунд эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах зардлын задаргааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Эрдэм шинжилгээний хуралд шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг холбогдох зардлаас тооцож олгохыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

3. Эрдэм шинжилгээний хурлыг удирдамжийн дагуу зохион байгуулахыг Залуучуудын зөвлөл (З.Ганбат)-д, албан хаагчдын оролцоог хангуулан дэмжлэг үзүүлж ажиллахыг нийт хэлтсийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ

Газрын даргын 2023 оны 08 дугаар
сарын 30-ний өдрийн А/47 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



УДИРДАМЖ

2023 оны 08 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах тухай

Нэг. Зорилго

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны түүхт 384 жилийн ойг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын дунд Улаанбаатар хотын өмнө тулгамдаж буй асуудал, шийдлийг хэлэлцэх, харилцан туршлага солилцох, албан хаагчдын эрдэм шинжилгээ судалгааны ажлын чадварыг сайжруулах, санал санаачилгыг дэмжих зорилгоор энэхүү эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулна.

Хоёр. Хурлын хамрах хүрээ

Хотын стандарт, хяналтын газрын нийт албан хаагчид оролцоно. (Хэлтэс бүрээс 1 ба түүнээс дээш албан хаагч)

Гурав. Хугацаа, газар

- Хурал 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр 13:00 цагт Нийслэлийн Нутгийн захиргааны төв цогцолбор байр, 1 давхрын "Хүндэтгэлийн танхим"-д болно.
- Эрдэм шинжилгээний хурлын хөтөлбөр, төлөвлөгөөг Залуучуудын зөвлөл боловсруулж батлуулна.

Дөрөв. Сэдвийн хамрах хүрээ

- Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад тулгамдаж буй асуудлын шийдэл;
- Нийгэм болон мэргэжлийн хүрээнд тулгамдаж буй асуудлын шийдэл;
- Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд хийгдэж буй судалгааны ажил.

Тав. Илтгэлд тавигдах шаардлага

Илтгэл нь хамрах сэдвийн агуулгын хүрээнд тоо баримт, статистик үзүүлэлт ашигласан, үзэл санаагаа товч тодорхой илэрхийлж, шинэ санал санаачилга тусгасан, байгууллагын чиг үүргийн хүрээнд үнэ цэнтэй нэг асуудлын шийдлийг эрж хайсан байна.



Бичвэрийн ерөнхий шаардлага:

1. Илтгэл нь: гарчиг, хураангуй, түлхүүр үг, оршил, үндсэн хэсэг, дүгнэлт, ном зүй гэсэн бүтэцтэй байна;
2. Нүүр хуудсанд илтгэлийн нэр, илтгэгчийн овог, нэр, ажил, албан тушаал, харилцах утасны дугаарыг бичих;
3. Илтгэлийн эхийг MS Word програм дээр 5-8 нүүрэнд багтаан Arial, үсгийн фонт 12, мөр хоорондын зай 1,15
4. Илтгэлд ашигласан эх сурвалжийг заавал тэмдэглэх (Иш татсан тохиолдолд тогтсон стандартыг баримтлах);
5. Үг, үсгийн болон утга найруулгын алдаагүй байх.
6. Илтгэлийг хэвлэмэл ба файлаар 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн дотор Залуучуудын зөвлөл (gachmaamandakh@gmail.com)-д ирүүлэхээс гадна илтгэхэд зориулж Power point-оор бэлтгэнэ.

Зургаа. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

- Судалгааны арга зүй ашигласан байдал;
- Тухайн сэдвийн судлагдсан байдал;
- Шийдэл, шинэ санаа дэвшүүлсэн байдал;
- Ишлэл зүүлт иш татсан байдал;
- Илтгэх чадвар;
- Эрдэм шинжилгээний бүтээлд тавигдах шаардлагыг хангасан байдал.

Долоо. Шүүгчдийн бүрэлдэхүүн

- Хотын стандарт, хяналтын газрын удирдах албан тушаалтны төлөөлөл – 1
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын удирдах албан тушаалтны төлөөлөл – 1
- Мэргэжлийн шүүгч – 1

Найм. Шагнал урамшуулал

1. Тэргүүн байр - Өргөмжлөл, 500.000 мянган төгрөг,
2. Дэд байр - Өргөмжлөл, 350.000 мянган төгрөг,
3. Гутгаар байр - Өргөмжлөл, 250.000 мянган төгрөг.

Эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн оролцогчдын бүтээлийг эмхэтгэл болгон хэвлүүлж байгууллагын архивын сан хөмрөгт хадгална.